



"Субашид"-ын монгол орчуулгууд

О. Дэмчигмаа* (МУИС)

Түлхүүр үг: Субашид, орчуулга, уламжлал, хэл шинжлэл, дорно орно.

Монголчууд орчуулгын өнө эртний түүхтэй бөгөөд ялангуяа XIII-XIV зууны үеэс санскрит төвд хэлнээс буддын шашны номлол сургаалыг зонхилон орчуулж байжээ. Энэ уламжлал үргэлжилсээр улам нарийн боловсронгуй болон хөгжиж ирсэн байна. Түүнчлэн нэг зохиолын хэд хэдэн орчуулга ч гарч байсны тодорхой баримт бол "Субашид"-ын орчуулгууд юм. "Субашид" хэмээх, 457 бадаг бүхий сургаалын зохиолыг Төвдийн алдарт эрдэмтэн Сажа бандида Гунгаажалцан 13 дугаар зууны үед зохиож, улмаар төвд, монголчуудын дунд өргөн дэлгэрсэн төдийгүй хэлмэрч гүүш нар монгол хэлнээ олонтаа орчуулжээ. Ерөөс Монголын уламжлалт орчуулгын нэг онцлог бол төвд утга зохиол, буддын шашны утга зохиолыг нэг бус хэд хэдэн удаа орчуулж байсан явдал бөгөөд энэ нь дэлхийн бусад ард түмний утга зохиолд нэг зохиолын олон орчуулга гарч байсантай адил үзэгдэл юм.⁶⁷ Ийнхүү урьд цагт монголын ард түмэн нүүдэллэн тархай бутархай аж төрж байсан явдал нэг номын олон орчуулга гарахад нөлөөлснөөс гадна тухайн ном бас ард олны үлэмж хэрэгцээтэй зохиол байснаас тийнхүү олон дахин орчуулсан буюу аливаа нэг орчуулгын хэл найруулгыг засан сайжруулах гэсэн оролдлоготой холбоотойгоор ч гарч ирсэн билээ.

"Субашид" хийгээд түүний тайлбарын бичгийн болон аман орчуулга олон буй. Эдүгээ бидэнд мэдэгдээд буй, бичгийн найман монгол орчуулга байна. Үүнд:

1. Тарнич тойн Сономгара-гийн орчуулга (XIII-XIV зуун. Гар бичмэл)
2. Ойрадын Зая бандида Намхайжамцын орчуулга (1650-1662. Тод үсгээр бичмэл)
3. Сөнөдийн Данзанчойдорын орчуулга (Тэнгэр тэтгэгч хаан /1736-1795/-ы зарлигаар. Гар бичмэл)

*МУИС-ийн МХСС-ийн Эх бичиг, алтай судлалын тэнхим, доктор

⁶⁷ Д. Бүрнээ, Д. Энхтөр. Уламжлалт монгол орчуулгын судлалд. УБ.2003.11.

4. Мэргэн гэгээн Лувсандамбийжалцан /1717-1766/-ы орчуулга (ХҮШ зуун. бар)
5. Цахар гэвш Лувсанчүлтэмийн орчуулга (1778-1779. бар)
6. Дана-гийн гэгээн буюу Төгөлдөрийн Галсанжинбын засварласан орчуулга (1889. бар)
7. Сумадираднаа /1820-1907/-гийн эхний орчуулга (Лувсанринчэн буюу Номтын Ринчэн ч гэдэг. XIX зуун. бар)
8. Сумадираднаагийн хоёр дахь орчуулга (XIX зуун)

Эл орчуулгууд хэдэн зууныг өртөөлсөн, монголын тэл хэлт дуун хөрвүүлэгчдийн бүтээлийн үр шим, үзэл баримтлал, мэдлэг чадварын цар хүрээг харуулах, орчуулгын үнэт судлагдахуун билээ.

Төвд хэлнээс арвин баялаг ном зохиолыг орчуулж байсан уламжлалын дунд дорно дахины зохиол бүтээлийг орчуулах чиг хандлага, арга зарчим боловсрон тогтсон байдаг Ерөөс монголчуудын орчуулсан бүтээл туурвилаас үзэхэд үндсэндээ 1. үгчилсэн, 2. утгачилсан хоёр янзын төлөв байдал ажиглагдана. "Субашид"-ын орчуулгуудыг судлан үзэхэд Сономгара, Зая бандида, Мэргэн гэгээн, Дана-гийн гэгээн нарын орчуулга үгчилсэн хэв шинжид, Цахар гэвш Лувсанчүлтэм, Сумадираднаа нарын орчуулга утгачилсан хэв шинжид хамаарах ажээ.

Сономгара "Субашид"-ыг 13 дугаар зууны үед орчуулсан гэдэгт эрдэмтэд санал нэгддэг. Энэ үеийн орчуулгын гол онцлог бол буддын шашин, буддын утга зохиолын нэр томъёоны орчуулга нэг мөр хэвшин тогтоогүй, санскрит гаралтай үг хэллэг зонхилж байсанд оршино. Сономгара-гийн орчуулга ерөнхийдөө судрын хэлний үгчилсэн орчуулгад хамаарах боловч уг төвд эхийн утга санааг алдагдуулахгүйгээр үгийн утгыг энгийн олонд ойлгомжтой, зөв оновчтой оноохыг эрхэмлэж, монгол шүлгийн онцлогт тохируулан толгой сүүл холбохыг урьдал болгоогүйн дээр зарим мөр, бадаг дахь үгсийн байрлалыг чөлөөтэй сольж, хувирган орчуулсан ч бий.

Зая бандид XIV зууны үеэс монгол орчуулгад баримталж байсан согд, уйгурын орчуулгын уламжлал буюу гүн ухааны нэр томъёо, оноосон нэр зэргийг санскритээр нь сэргээн буулгадаг байсан тэр зарчмыг мөрдсөнгүй, төвд эхээс нь монголоор ягштал үгчлэн орчуулжээ. Гэхдээ эрт монгол хэлнээ орж нэгэнт хэвшин тогтсон зарим үгийг санскрит, уйгураар нь авахын сацуу оноох уугал үг байхгүй тохиолдолд төвдөөр галиглан буулгасан, нутгийн аялгууны үгээр орчуулсан байна.

Мэргэн гэгээний орчуулгыг бүхэлд нь ажиглахад Өрнө дахины уран зохиолын орчуулгын гол чиглэл болох хэт үгчлэх, хэт чөлөөтэй орчуулах хоёр хэтийдлээс зайлсхийж, эх зохиолтой нь агуулга, хэлбэрийн хувьд дүйцүүлэх зарчимтай адилавар юм. Ерөнхийдөө төвд эхийнх нь утга санааг алдагдуулахгүйг эрхэмлэсэн гэж хэлж болохоор бөгөөд толгой холбож орчуулсан бадаг маш цөөн буй. Зарим үгийг орчуулаагүй орхисон, заримыг нэмсэн, ойролцоо үгээр орчуулсан, шууд төвд, санскритаар нь хуулбарлан авсан, утга дагуу ойлгомжтой үгээр сольж орчуулсан, нэг үгийг нэлээд олон утгаар, дан үгийг холбоо үгээр, холбоо үгийг дан үгээр орчуулсан, илт өгүүлэх нэр, оноосон нэрийг орчуулахдаа уламжлалт орчуулгын зарчмуудыг баримталсан ажээ.

Дана-гийн гэгээн Мэргэн гэгээний орчуулгыг засварлан найруулахдаа 457 бадгаас нийт 283 бадагт ямар нэг хэмжээгээр гар хүрч засварласан байх бөгөөд тийн ялгалын нөхцөлөөс эхлээд нэг, хоёр, гурван үг болон ихэвчлэн нэг мөрт засвар оруулж, хэлзүйн хувиргал хийжээ. Ингэхдээ 1. үгийг сольсон, 2. хэлбэрийг өөрчилсөн, 3. Үг нэмсэн, 4. Үг хассан, 5. Үгийн байр сольсон зэрэг гол төлөв хэлзүйн хувиргал хийсний сацуу Мэргэн гэгээний орчуулгад төвд эхийн мадаг зөрөөнөөс хамаарсан болов уу гэлтэй утгын хувьд эхтэйгээ тохирохгүй мөр бадгууд буйг засч орчуулжээ. Мэргэн гэгээний шууд бодот үгээр орчуулсан оноосон нэрийн ихэнхийг Дана-гийн гэгээн санскритаар сэргээн буулгасан байна.

Цахар гэвш Лувсанчүлтэмийн орчуулга бүхэлдээ толгой холбон утгачилсан чөлөөт орчуулга юм. Чингэхдээ зөвхөн толгой холбох, үг нэмж хасч солих төдийхнөөр зогсохгүй энгийн олон ойлгоход төвөггүй, хялбар, оновчтой үгээр оноож, зарим бадгийг тайлбарлан шүлэглэсэн буй. Ерөөс уг орчуулга бол төвд эхээс нэлээд хазайсан хийгээд шашны ойлголтыг иргэншүүлж, харийн ахуйг монголжуулж, нарийн явцуу утгыг ерөнхийлсөн тул зарим судлаачид дуурайлган зохиосон монгол субашид⁶⁸ хэмээн үзэх нь бий.

Сумадираднаагийн орчуулга Цахар гэвшийнхтэй төстэй, утгачилсан орчуулгад хамаарах хэдий ч уг төвд эхийн утгыг хэт холдуулж өөрчлөлгүй толгой холбон үг нэмж орчуулснаараа онцлогтой. Тэрбээр оноосон нэрийг санскритаар сэргээн буулгах, илт өгүүлэх нэрийг нуусан нэрээр нь монголчлох зарчмыг эрхэмлэсэн нь "Мэргэд гарахын орон"-д тогтоосон журмыг баримталсан гэж үзвэл зохилтой.

⁶⁸Л. Хүрэлбаатар. *Монгол орчуулгын товчоон*. УБ. 1995. 158.

Эдгээр орчуулгыг судлахад өрнө, дорнын орчуулгын онолын арга зарчим харагдаж байна. Аливаа зохиолын утгыг эх хэлнийхээ хэм хэмжээнд бүрэн дүүрэн, үнэн зөв буулгахад үгийн сангийн хувиргалыг зайлшгүй хийх шаардлагатай байдаг. Харь хэлний үгийн хам үгтэйгээ хамтран гаргаж байгаа утгыг олж, толинд зааснаас өөр тохирлыг оноохдоо хэрэглэдэг логик-сэтгэхүйн аргыг үгийн сангийн хувиргал гэнэ⁶⁹ хэмээн Оросын эрдэмтэн Я.И.Рецкер тодорхойлсон бөгөөд нарийвчлах, ухагдахууны учир шалтгааны өрнөлөөр орчуулах, эсрэг утгаар орчуулах, нөхөх зэрэг дөрвөн арга байна гэж дурджээ⁷⁰. Л.С.Бархударов орчуулгын хувиргалд өгүүлбэрийн бүтцийг өөрчлөх (перестановка), солих (замены), нэмэх (добавления), орхих (опущения) гэсэн дөрвөн аргыг авч үзээд, солих арга дотор нь үгийн хэлбэрийг солих, үгсийн аймгийг солих, өгүүлбэрийн гишүүнийг солих, нийлмэл өгүүлбэрийн бүтцийг солих (энгийн өгүүлбэрийг нийлмэл өгүүлбэрээр солих, нийлмэл өгүүлбэрийг энгийнээр солих, гол өгүүлбэрийг гишүүн өгүүлбэрээр гишүүн өгүүлбэрийг гол өгүүлбэрээр солих, хавсарсан өгүүлбэрийг энгийнээр, энгийн өгүүлбэрийг хавсарснаар солих, холбоос үгийг солих гэх мэт), үгсийн сангийн хүрээнд солих арга, (нарийвчлах, ерөнхийлөх), эсрэг утгаар орчуулах, нөхөх гэх зэргээр хувааж үзсэн байна.⁷¹ Ерөөс үгийн сангийн хувиргалыг оновчтой хийснээр орчуулга төгс төгөлдөр болдог учир орчин цагийн орчуулгын онолын үндсэн зарчим ч гэж үздэг. Өрнө дахины орчин үеийн орчуулгын онолын эдгээр бүхий л арга зарчмыг "Мэргэд гарахын орон" толь бичигт журамлан заасны зэрэгцээ тус эрдэм хийгээд гэм алдлыг сайтар бодож орчуулахыг анхааруулсан буй. Тухайлбал: "... үг, утгын хувийг сайтар шинжлээд ... мэдэхүйеэ хялбар үгсээр утга лугаа үл харшилдуулан орчуулах ..." тухай гол үндэслэгээг дэвшүүлж, орчуулгад цөөн хэдэн үгэнд баригдаж утгын чадлыг явцууруулах, эсвэл илүү олон үгийг нэмж утгын хувийг халхлах гэмийг хааж, үгийн олон утгыг урьд хойд үгтэй нь зөвөөр оноон дүйцүүлэх, орчуулах боломжгүй, монгол хэлнээ хоёр утгыг илтгэх үг эс олдвол уг үгийг харь хэлний үгээр нь авах, энэтхэг, төвд тусгай нэрийн зүйлийг нэгэн нэрийг нэмж мөнхүү энэтхэг буюу төвд нэрээр нь авах, зохиолын уг эх болон холбогдох тайлбарт гарч байгаа нэр томъёог нэг болгон жигдлэх, магтах, муулах, гайхах, уйтгарлах, айхын олон аялга үгийг нийтэд тодорхой, "их чадалт сэтгэлийг хөдөлгөн чадах" үгээр орчуулах, зохиогчийн санаа болон зохиолд өгүүлсэн зүйлийн утга санааг орчуулагчаас дур мэдэн засахыг хориглох, шүлэглэсэн зүйлийг яруу найртай утга төгс

⁶⁹ Г. Аким. *Орчуулгын санг уудлахад*. Уб. 1984. 26.

⁷⁰ Д. Бүрнээ, Д. Энхтөр. *Уламжлалт монгол орчуулгын судлалд*. Уб. 2003. 115.

⁷¹ Л.С.Бархударов. *Язык и перевод*. М. 1975. 191-226.

мэдэхүйеэ хялбар үгээр, бадаг мөрийг сайтар тэгшитгэн орчуулах, толгой холбох нь харшлах зүйлгүй боловч тийнхүү холбохын тулд олон илүү үг орсноор утга далдлагдахын тул сайтар хянах, хэрэв нэр томъёог шинээр найруулах хэрэгтэй бол өөрийн дураар бус, орчуулахын хүрээ дор тулгаж гол ба учир шалтгаан лугаа харшуулалгүй орчуулах, гүн ухааны баталсан сөхөөсөн үгсийг хурц бөгөөд мэдэхүйеэ амар үгээр орчуулах⁷² гэж зааснаас үзвэл өрнө, дорнын орчуулгын онол тохирч байгаа нь харагдана. Тухайлбал, "... үгийн олон утгыг урьд хойд үгтэй нь зөвөөр оноон дүйцүүлэх ..." гэсэн нь үгийн сангийн олон утгатай үгийг хам сэдвийн хүрээнд авч үзэж, тохирох утгыг оноохыг хэлжээ.

"Субашид"-ыг орчуулагч нар дээрх аргуудыг бүтээлчээр хэрэгжүүлсэн байна. Утгыг ерөнхийлөх, өрнүүлэх, нарийвчлан тодруулах, үг нэмэх, хасах, солих зэрэг үгийн сангийн хувиргалыг өргөн хэрэглэсэн буй. Үг нэмэх, хасах, солих хувиргал бадагт бүрт тохиолдоно. Бусад аргыг тодорхойлбол:

Утгыг ерөнхийлөх

Харь хэлний явцуу утгатай үгийг ерөнхий утгатай үгээр солих буюу эх зохиолд тодорхой өгүүлсэн зүйлийг ерөнхийлөн орчуулах арга. Жишээ нь: *mi bsrun 'gro*. Үгчилбэл. Догшин ширүүн амьтан, ЦГ. *asuru buruуu yabuүcin*

Утгыг өрнүүлэх

Юм үзэгдэл үйл явдлын шүтэн барилдлагад тулгуурлаж шалтгаан нөхцөлөөс гарах үр дагаварыг урьдчилан харж орчуулах арга. Жишээ нь: *mgo skor yang*. Үгчилбэл. Толгой эргэх, толгой эргүүлэх, СГ. *aryadaydabasu*

Утгыг нарийвчлан тодруулах

Гадаад хэлний өргөн утгатай үгийг явцуу утгатай үгээр орчуулах арга. Жишээ нь: *mi bsrun 'gro*. Үг. Догшин ширүүн амьтан, СГ. *doysin aran, srin bu'i kha chu*. Үгчилбэл. Хорхойн шүлс, МГ. *ayal...in-u silüsün*.

Аливаа хэлэнд тухайн улс орон, ард түмний амьдрал ахуй, зан заншил, нийгэм соёлын онцлогийг тусгасан эд өлөг, юм үзэгдлийн нэр, агуулгыг тэрхүү ард түмний хэлээр илэрхийлсэн үгс цөөнгүй байдаг. Ийм үгсийг бусад хэлээр орчуулах боломжгүй. Манай эрдэмтэн судлаачид үүнийг үндэсний онцлогт үг гэж нэрлээд дотор нь хэд хэд ангилсан буй. Үндэсний онцлогт үгс хөрдмол утгагүй бөгөөд үндсэндээ нэр томъёоны утгыг илэрхийлж чадна. Үүнд: оноосон нэр, хэлц үг, төрөл бүрийн амьтан, ургамал, өвчин эмгэг, эд юмсын нэрээс гадна Энэтхэг, Төвдийн ахуй соёлыг тусгасан илт өгүүлэх нэр, шашин соёлын холбоотой үг хэллэг мөн багтах юм.

⁷² Л. Хүрэлбаатар. *Монгол орчуулгын товчоон*. УБ. 1995. 155.

Үндэсний онцлогт үг (реал)-ийг орчуулах дараах арга зарчмууд байдаг. 1. Үсэгчлэн галиглаж буулгах(энэ бол хамгийн түгээмэл арга юм), 2. Хуулбарлах буюу үгчлэх (тухайн хэлний үгийг үгчлэн хуулбарлаж орчуулах арга), 3. Шинэ үг буюу холбоо үг үүсгэж орчуулах, 4. Ойролцоо утгатай үгээр оноох, 5. Дурдсан аргуудаар орчуулах боломжгүй тохиолдолд утга санааг тайлбарлан орчуулах юм.

Дуун хөрвүүлэгчид эдгээр үгсийг хэрхэн оноон буулгасныг ажиглахад үндэсний онцлогт үгийг орчуулах, орчин үеийн орчуулгын онолын арга зарчмын үгчлэн галиглаж авах, ойролцоо утгатай үгээр оноох арга зарчимтай нийцэж байна. Жишээлбэл: *sna ma'i me tog*. Энэхүү цэцгийн нэрийг төвд монгол толь бичгүүдэд голдуу "задийн цэцэг, цахирмаа цэцэг" гэж оноосон бөгөөд СГ. *sümen čečeg*, ЗБ. *sambaya cecceg*, МГ. *sanma-yin sečig*, ДГ, ЦГ. *zadi-yin sečig*, СР. *čakirm-a-yin čečeg* хэмээн орчуулцгаажээ. Төвд-англи толь бичгүүдэд: англиар *jasminum grandiflorum*, *jasmine flower* -мэлрэг, малига, *nutmeg* - задийн цэцэг, санскритаар *mālātī* хэмээн тэмдэглэсэн байна.⁷³ *skyu ru ra*. Сономгара, Дана-гийн гэгээн, Сумадираднаа нар "Imiti" гэж, Зая бандида "skyii-rii-ra" хэмээн төвдөөр нь галиглан буулгасан бол Цахар гэвш "doluuna" гэж ойролцоо ургамлын нэрээр орчуулжээ.

Дүгнэвэл, орчуулгуудыг цуваа цагийн үүднээс авч үзвэл, ерөнхийдөө ХIY-XIX зууны орчуулгад ноёрхож байсан орчуулгын үндсэн чиг хандлага буюу төвд эхийг ариунаар буулгана хэмээсэн буддын шашны чин сүсэг бишрэлийн үүднээс төвд эхийн үг үсгийг хуулбарлан буулгаж байсан үгчилсэн орчуулгын зэрэгцээ утга төгөлдөр уран яруу орчуулгын чиг хандлага байсан төдийгүй урьд өмнө гарсан орчуулгыг төвд эхэд ойртуулан хянан засварлаж байсан баримт ч харагдаж байна. Үүний зэрэгцээ өрнө дорнын орчуулгын арга зарчим үндсэндээ тохирч буйг эдгээр орчуулгуудыг судалсны дүнд ажигласан болно.

⁷³ S.Ch. Das. *Tibetan english dictionary*. Calcutta. 1902.765, Ю.Н.Перих. *Tibetan-Russian-English dictionary with Sanskrit parallels*. USSR. Academy of Sciences Institute of Oriental Studies. M.1983.5.146, James Bosson. *A Treasury of Aphoristic Jewels; the Subhasitaratnanidhi of Sa Skya Pandita and Mongolian, - Uralic and Altaic series*, Vol.92, Indiana Univer., Bloomington. 1969. 209.

Ашигласан ном зохиол

1. Аким. Г. *Орчуулгын санг уудлахад*. Уб. 1984.
2. Бархударов. Л.С. *Язык и перевод*. М. 1975.
3. Бүрнээ. Д, Энхтөр. Д. *Уламжлалт монгол орчуулгын судлалд*. Уб. 2003.
4. Рерих. Ю.Н. *Tibetan-Russian-English dictionary with Sanskrit parallels*. USSR. Academy of Sciences Institute of Oriental Studies. М.1983.
5. *Сайн номлолт эрдэнийн сан Субхашида нэрт шастир оривой*. Буриад модон барын хэвлэл. Хуудас 61. УННС-ийн монгол фондын 2586. с-557 тэмдэгтэд.
6. “Сайн үгт эрдэнийн сан нэрт шастир”. Зууннаст, Сэцэнцогт харгуулан тайлбарлав. Монгол тулгуур бичгийн цуврал. ӨМАХХ. 1989.
7. Хүрэлбаатар. Л. *Монгол орчуулгын товчоон*. Уб. 1995.
8. *Эрдэнийн сан нэрт сайн номлол оривой*. Буриад модон барын хэвлэл. Хуудас. 60. МҮНС-ийн монголын фондын 2581, с-557 тэмдэгтэд.
9. *Эрдэнийн сан нэрт сайн үгт шастир*. Мэргэн гэгээн Лувсандамбийжалцаны орчуулга. Бээжин барын судар. 78 хуудас.
10. *Эрдэнийн сан нэрт сайн үгт шастир*. (орчуулга дахь нэрээр). Ц.Дамдинсүрэнгийн гэр музейд.
11. Bosson James. *A Treasury of Aphoristic Jewels; the Subhasitaratnanidhi of Sa Skya Pandita and Mongolian*, - Uralic and Altaic series, Vol.92, Indiana Univer., Bloomington. 1969.
12. *Dag yig mkhas pa'i 'byung gnas*. Mongyul tulγur bičig-ün čubural. Ündüsüiten-ü keblel-ün qoriy-a. 1988. *dag yig gsar bsgrigs*. Mtsho sngon. 1979.
13. Das. S.Ch. *Tibetan english dictionary*. Calcutta. 1902.
14. Luvsanbalдан. Ch. *Le subhasitaratnanidi. Subhaeta kemeku sudur orosibai*. Acta Orientalia. Hungaria. XXVI. 1972.
15. *Sa skya'i legs bshad kyi rtsa 'grel*. Mtsho sngon mi rigs dpe skrun khang. Zi ling. 1995.

“Subhāṣita, a collection of four hundred and fifty seven quatrains expressing civic and didactic aphoristic sayings and similes, was written in 13th century by Tibetan famous scholar Sa skya Pandita Kun dga' gyal mtshan. The work has for many centuries enjoyed a great popularity among the Tibetans and the Mongols as a model of literary composition and didactic writing. Today eight kinds of Mongolian literary translation are known. Such as:

1. The translation by exorcist monk Sonomgara, (XIII-XIV centuries, manuscript)
2. The translation by Oirat's Zaya pandita Namkhajamtso (1650-1662, on Oirat script, manuscript)
3. The translation by Suned's Danzanchoidar (according to the edict of Tenger tetgegh of Manchu /1736-1795/, manuscript)
4. The translation by Mergen gegeen Luvsangdambiijaltsan (1717-1766, XVIII century, xylography)
5. The translation by Tsahar gevsh Luvsantshultim (1778-1779, xylograph)
6. Revised translation by Dāna gegeen or Tugulduriin Galsangjinba (1889, xylograph)
7. The first translation by Sumatiradna /1820-1907/ (other name Luvsangrinchen or Nomtiin Rinchen, XIX century, xylograph)
8. The second translation by Sumadiradna (XIX century)

They are very interesting and important for the translation theory and linguistics. We have studied Mongolian translations, especially the peculiarities and differences of every translation in this article. The translators frequently used the translation transformations such as, detailing, generalizing and expanding the meaning. Also, we have made a comparative study on the translations based on the proper nouns, synonyms, animals' and plants' names. While studying these translations of Subhāṣita, we observed Eastern and Western translation methods and summarized that both of the methods are practically adequate.